



# АРХАНГАЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## ХҮН АМ НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА



2019 ОН

## **ОРШИЛ**

Хүн ам зүйн судалгаанд хүн амын нас, хүйсийг судлах нь хүн ам, нийгэм, эдийн засгийн бодлого боловсруулах, хүн амын хүчин зүйлсийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинжилгээнд тусгахад чухал ач холбогдолтой. Хүн амын нас, хүйсийн байдал нь нийгэм, эдийн засаг, соёлын асуудлуудтай нягт холбоотой байдаг учраас түүнийг шинжлэх шаардлагатай байдаг. Тухайлбал сургуульд хамрагдалт, ажиллах хүчний нөөц, гэрлэх, төрөх, шилжих гэх мэт. Түүнчлэн зарим нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ нь нас, хүйсийн бүтцээс хамааран өөр өөр байдаг. Нас, хүйсийн бүтцийн мэдээлэл нь нийгмийн чиг хандлагыг тайлбарлах, зах зээлийг тодорхойлох, ирээдүйн төлөвлөлт хийхэд чухал ач холбогдолтой. Мөн нийгмийн мөн чанар, функцийг ойлгоход чухал байдаг. Үүний зэрэгцээгээр хүн амын түүхэн хөгжил хувьслыг болон ирээдүйн хэтийн төлөвийг тодорхойлдог.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгаанд Архангай аймгийн 2014-2018 оны хүн амын тоо, өсөлтийн өөрчлөлт, нас хүйсийн бүтэц, хүн амын төрөлт, дундаж наслалт, өрхийн өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн гэх зэрэг хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд, тэдгээрт гарсан өөрчлөлт болон хүн амын нийгмийн зарим үзүүлэлтүүдийн талаархи санал дүгнэлт гаргахийг зорилоо.

Судалгааны аргачлал:

Судалгааг гаргахын тулд 2014-2018 оны суурин хүн амын жилийн эцсийн тайлан, хүн амын ердийн хөдөлгөөний тайлан, хүн амын шилжилт хөдөлгөөний тайлан мэдээний үзүүлэлтийг ашиглан судалгааг хийлээ.



## ТОДОРХОЙЛОЛТУУД

### ***Суурин хүн ам***

Тухайн баг, хорооны нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа бүх хүнийг суурин хүн ам гэж үзнэ. Мөн бсараас доош хугацаагаар түр эзгүй байгаа байнга оршин суудаг хүмүүсийг суурин хүн амын тоонд оруулна.

### ***Өрх***

Хүн ам, өрхийн тоог хот, тосгон, сумын төв, хөдөөгөөр гаргана. Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэж үзнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн болон гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.

### ***Хотын хүн ам***

Хотын хүн амд аймгийн төвийн хүн амын тоог оруулан тооцсон болно.

### ***Хөдөөгийн хүн ам***

Хөдөөгийн хүн амд сумын төв, хөдөөгийн /баг/ хүн амыг оруулан тооцсон болно.

### ***Гэрлэлт***

Тухайн нутгийн засаг захиргааны нэгжид гэр бүл болсноо бүргүүлсэн хүмүүсийг бүртгүүлсэн гэж үзнэ.

### ***Цуцлалт***

Гэрлэлтээ зохих шатны шүүхээр цуцлуулж, цуцлалтаа бүртгүүлсэн бол гэр бүлээ цуцалсанд тооцно.

### ***Үрчлэлт***

Үрчлэн авагч нь хүүхэд үрчлэн авсан тухайгаа иргэний гэр бүлийн асуудал эрхэлсэн тухайн шатны албанд бүртгүүлж, гэрчилгээ авсан тохиолдолд үрчлэгдсэн гэж үзнэ.

### ***Ердийн хөдөлгөөн***

Төрөл, нас баралт, гэрлэлт, цуцлалт, үрчлэлтийг хүн амын ердийн хөдөлгөөн гэнэ.




## Архангай аймгийн хүн ам

Архангай аймагт 2018 оны эцэст 48097 эрэгтэй, 47897 эмэгтэй буюу нийт 95994 хүн байнга оршин сууж байгаа нь Монгол улсын хүн амын 3.0 хувьтай тэнцэж байна.




Аймгийн хүн амын тоо сүүлийн 4 жил тогтмол өсч байгаа нь доорхи графикаас харагдаж байна. Мөн ҮСХорооноос хийсэн хүн амын хэтийн

### ХҮН АМ /мян. хүн/




тооцооноос үзэхэд Архангай аймаг 2025 онд 98520, 2035 онд 104748, 2045 онд 116252 болж өснө гэсэн үр дүн гарсан байсан. Манай аймгийн хүн амын 23.1 хувь буюу 22138 хүн ам аймгийн төвийн Эрдэнэбулган суманд амьдарч байна. Эрдэнэбулган сум нь 0.01 мян.км2 газар нутагтай буюу аймгийнхаа бусад сумуудтай харьцуулахад газар нутгийн хувьд хамгийн бага харин хүн амын хувьд хамгийн их байгаа нь хүн амын төвлөрөл аймгийн төвд хамгийн их байгааг харуулж байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар Эрдэнэбулган, Цэнхэр, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Ихтамир сумд аймгийн хэмжээнд олон хүн амтай байна.




Харин Өгийнуур, Хангай, Төвшрүүлэх, Булган, Цахир сумууд хамгийн бага хүн амтай байна.




### Архангай аймгийн хүн амын нас, хүйсийн суварга, 2018 он

Манай аймгийн хүн амын нас хүйсийн суваргын бүтцийн хувьд 0-39 насанд эрэгтэйчүүд олон 40-44 насанд эмэгтэйчээд олон 45-49 насанд эрэгтэйчүүд олон, 50 дээш насаны эмэгтэйчүүд олон байгааг харахад эмэгтэй хүмүүс сүүлийн насанд нь олон байгаа нь эмэгтэйчүүд эрчүүдээс арай урт наслаж байгааг харуулж байна. Суваргаас харахад 0-4 насны хүүхэдийн тоо их нь цаашинд сургууль цэцэрлэгийн эрэлт хэрэгтэй байгааг хариулж байна.



### Архангай аймгийн суурин хүн амын тоо, нас хүйсийн бүтэц

Архангай аймгийн нийт хүн амын 65,1 хувь нь 15-64 настай, 30,5 хувь нь 0-14 настай, 4,1 хувь нь 65 аас дээш настай байна.



Архангай аймгийн хүн амын хүйсийн харьцаа 100.4 болсон бөгөөд энэ нь хүн амын нас баралтад эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгаатай холбоотой.

Хүн амын тоо хэмжээний өсөлтийг жилээр харьцуулж харах, хүйсийн бүтэц нэг хэвийн биш байгаа эсэхийг хараад шууд мэдэхэд ойлгомжтой, тохиромжтой байх үүднээс суваргыг бодит тоогоор (хувийн жингээр биш) зурсан.

### Хүн амын нас, хүйсийн бүтэц

	1979	1989	2000	2017	2018
Хүн ам -Бүгд	77569	84517	97091	94923	95994
эрэгтэй	38959	42190	48579	47563	48097
эмэгтэй	38610	42327	48512	47360	47897
<b>Насны бүлгээр</b>					
0-14	35860	36706	38101	28420	29267
15-64	37273	44037	54167	62529	62635
65+	4436	3774	4823	3974	4092
<b>Эрэгтэйчүүдийн эзлэх хувь</b>	50.2	49.9	50	50.1	50.1
<b>Эмэгтэйчүүдийн эзлэх хувь</b>	49.8	50.1	50	49.9	49.9
<b>Насны бүтэц, хувиар</b>					
0-14	46.2	43.4	39.2	29.9	30.5
15-64	48.1	52.1	55.8	65.9	65.1
65+	5.7	4.5	5	4.2	4.1
<b>Хүйсийн харьцаа</b>	100.9	99.7	100.1	100.4	100.42

### Хүн ам зүйн ачаалал

Хүн ам зүйн ачаалал (ХАЗА) гэдэг нь хөдөлмөрийн насны 100 хүн ногдох хөдөлмөрийн бус насны (15 хүртлэх, 65 ба түүнээс дээш насны) хүн амын тоог хэлдэг. Энэ нь хөдөлмөрийн насны 100 хүн өөрөөсөө гадна хэдэн хүүхэд, хөгшдийг тэжээж байгааг хялбар байдлаар хэмжих арга юм. Өөрөөр хэлбэл хүн амын насны бүтцээс хамааран эдийн засагт ямар ачаалал үүсч байгааг уг үзүүлэлтээр ойролцоо байдлаар хэмжиж болно.

#### ХАЗА нийт 53.2

ХАЗАхүүхдийн 46.7

ХАЗА хөгшид 6.5

### ХАЗА – Хүн ам зүйн ачаалал

$XA_{(0-14)}$  - 0-14 насны хүн амын тоо

$XA_{(65+)}$  - 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо

$XA_{(15-64)}$  - 15-64 насны хүн амын тоо

Хүн ам зүйн ачаалал /сумаар/


Хүн амын дундаж наслалт

$$ХАЗА = \frac{XA_{(0-14)} + XA_{(65+)}}{XA_{(15-64)}}$$

	2014	2015	2016	2017	2018
Архангай	70.5	71.1	70.8	70.8	71.3
Улсын дундаж	69.6	69.9	69.6	69.9	70.2

Аймгийн хүн амын дундаж наслалт 71.3 болж, өмнөх оноос 0.5 жилээр уртасжээ. Манай аймгийн дундаж наслалт сүүлийн 5 жилд улсын дундаж наслалтаас дээгүүр байна.

Дундаж наслалт /графикаар/



### Шилжих хөдөлгөөн

Шилжилт хөдөлгөөн гэдэг нь хүн амын байнга оршин суудаг газраа тусгайлан тогтоосон засаг захиргааны болон газар зүйн нэгж хооронд сэлгэн өөрчлөх

үйл явц юм. Шилжих хөдөлгөөнийг улс орны хил хязгаар давсан эсэхээр нь шалгуур болон гадаад ба дотоод шилжих хөдөлгөөн гэж ангилдаг.

Он	Шилжин ирсэн	Шилжин	Нийт шилжилтийн	Шилжин ирэлтийн	Шилжин явалтын	Цэвэр шилжилтийн
		явсан	коэффициент	коэффициент	коэффициент	коэффициент
2014	570	2337	31.37	0.62	25.2	-19.1
2015	637	1706	25.31	0.69	18.4	-11.5
2016	667	1226	20.38	0.72	13.2	-6
2017	1022	744	18.74	1.08	7.9	3
2018	846	767	16.90	0.89	8.0	0.8

Шилжих хөдөлгөөн бол хот болон төв суурин газрын хүн амын өсөлтийн нэг чухал хүчин зүйл бөгөөд хүн амын дунд хотжих үйл явц хурдацтай өрнөж байна.


Архангай аймгийн шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент нь 2014 оноос хойш (-) тэмдэгтэй гарч байгаа нь тухайн аймгийн шилжин явалт нь шилжин ирэлтээсээ илүү байгааг харуулж байна. Харин 2017 онд цэвэр шилжилтийн коэффициент (+) гарч байгаа нь хотруу шилжилт хийхийг хориглосонтой холбогдолтой гэж үзэж байна.

Дотоод шилжих хөдөлгөөн нэмэгдсэнээр зарим сумын сургууль цэцэрлэгийн анги дүүргэлт багасах, төв суурин газарт анги дүүргэлт болон эмнэлгийн үйлчилгээний ачаалал нэмэгдэх хандлагатай болж байна.

## Төрөлт

Төрөлт нь хувь хүн, хосууд, хүн төрөлхтний дунд явагдаж буй нөхөн үржихүйн бодит үзэгдэл бөгөөд эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор хэмжигдэнэ. Төрөлтийн талаарх тоо мэдээллийг иргэний бүртгэл, эрүүл мэндийн

статистик бүртгэл, хүн амын тооллого, тусгайлсан түүвэр судалгаа зэрэг мэдээллийн эх үүсвэрүүдээс авах боломжтой юм. 2018 онд төрсөн эхчүүдийн насны бүлгээр авч үзэхэд 20-24 насны эмэгтэйчүүдийн төрөлт хамгийн их байна.



Төрөлтийн коэффициентүүд, насны бүлгээр

Төрөлтийн түвшиг эмэгтэйчүүдийн насны бүлэг тус бүрээр тооцож дараах байдлаар харууллаа.

Насны бүлэг	эмэгтэйчүүдийн тоо	төрөлтийн тоо	Насны бүлэг дэхь төрөлтийн коэффициент
15-19	4043	137	33.9
20-24	4149	743	179.1
25-29	3815	663	173.8
30-34	3391	433	127.7
35-39	3222	238	73.9
40-44	3305	57	17.2
45-49	2914	4	1.4

$$ТНК = \frac{n * \sum НБТК}{1000}$$

ТНК – Төрөлтийн нийлбэр коэффициент

*n* - НБТК-ийг тооцсон насны бүлгийн интервалын урт

НБТК - Насны бүлэгдэх төрөлтийн коэффициент

$$ТНК = \frac{5*(33,9+179,1+173,8+127,7+73,9+17,2+1,4)}{1000} \approx 3,03$$

Төрөлтийн нийлбэр коэффициент 3.03 гарсан нь нэг эмэгтэйн нөхөн үржихүйн амьдралын хугацаанд дунджаар 3 хүүхэд төрүүлж байгааг харуулж байна.


ТЕК-төрөлтийн ерөнхий коэффициент

ТГК- төрөлтийн тусгай коэффициент

ТНК- төрөлтийн нийлбэр коэффициент

Сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдэх хандлагатай байна. 2011 онд төрөлтийн нийлбэр коэффициент 2.69 байсан бол энэ онд төрөлтийн нийлбэр коэффициент 3.03 болсон нь төрөлт өссөнийг харуулж байна.

## Нас баралт



Сүүлийн жилүүдэд хүн амын нас баралтын түвшин нилээд тогтвортой байна. 2018 онд нийт 609 хүн нас барснаас эрэгтэй 350, эмэгтэй 259 байна.. Нас барсан хүн амын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр хэвээр байгаа нь нас ахих тусам 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо цөөрч,

эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаагийн гол шалтгаан болж байна. Сүүлийн таван жилийн нас баралтын байдлыг авч үзэхэд нийт нас барсан хүний дунд эрчүүдийн нас баралт 2014 онд 58.4 хувь, 2015 онд 61.3 хувь, 2016 онд 59.4 хувь, 2017 онд 60,0 хувь 2018 онд 57,5 хувийг эзлэж байгаа нь эрчүүдийн нас баралт өндөр байгааг харуулж байна.

Төрөхийн улмаас эндсэн эх, үр хөндүүлсэн эхчүүдийн тоо, нялхсын нас баралт, нялхсын нас баралтын коэффициент


Он	Төрөхийн улмаас эндсэн эх	Үр хөндөлт	Нялхсын нас баралт	Нялхсын нас баралтын коэффициент
2014	1	186	29	13.01
2015	0	224	29	13.48
2016	2	212	37	17.36
2017	0	234	32	16.82
2018	2	254	34	19.6

2014-2018 оны байдлаар манай аймгийн хувьд нялхсын эндэгдэл өндөр байгааг хүснэгтээс харж болох юм. Энэ нь жирэмсэн эхчүүдийн эрүүл мэндийн байдал, хоол тэжээл, эмнэлгийн тусламж үйлчилгээнээс шалтгаалах төдийгүй байгаль цаг уурын гэх мэт олон хүчин зүйлс нөлөөлж байна.

### Өрхийн аж байдал

2019 оны 1-р сарын 1-ний байдлаар Архангай аймагт нийт 27912 өрх оршин сууж байгаагийн 21,8 хувь буюу 6087 өрх Эрдэнэбулган суманд амьдарч байна. Өрхийн тоо 2017 оныхоос 1,3 хувиар өссөн байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 2484 эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна. Өрхийн тоог сум бүрээр үзвэл Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Цэнхэр, Ихтамир сумд хамгийн олон өрхтэй байна.

## Өрхийн тоо




## Өрхийн зарим үзүүлэлт 2017, 2018 он


	2017	2018
Ихэр хүүхэдтэй өрхийн тоо	237	244
2 ихэр хүүхдийн тоо	474	488
18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх	1971	1590
Ганц биеэрээ амьдарч буй ахмад настай	1577	2016
Өрхийн дундаж ам бүл	3.4	3.4

## Гэрлэлт, цуцлалт

2018 онд 469 хос гэрлэлтээ шинээр бүртгүүлсэн нь 2014 оноос 13 гэрлэлтээр, харин 2015 оноос 36 гэрлэлтээр, 2016 оноос 158, 2017 оноос 29 гэрлэлтээр тус тус өссөн байна.



..



2014 оноос хойш сүүлийн таван жилийн гэр бүл цуцлалтын байдлыг дээрх графикаар харууллаа. Гэрлэлт цуцлалтаас үүдэлтэйгээр хүүхдийн эрх ашиг хөндөгдөж байгаа нь ихээхэн сэтгэл эмзэглүүлсэн асуудал юм.



## ДУГНЭЛТ

Манай аймгийн хүн амын нас хүйсийн бүтцийн харьцааг авч үзэхэд харьцангуй тогтвортой байгаа, дундаж наслалт улсын дунджаас дээгүүр байгаа зэрэг нь харьцангуй сайн үзүүлэлт байна. Хүн ам зүйн ачааллын хувьд 2018 оны жилийн эцсийн байдлаар 0-14 насны хүүхдийн тоо 29267, 15-64 насны хүн амын тоо 62635, 65 дээш насны хүн амын тоо 4092 байгааг хүн ам зүйн ачаалал тооцох аргачлалаар тооцоход хөдөлмөрийн насны 100 хүн өөрөөсөө гадна 46-47 хүүхэд, 6-7 тэтгэвэрийн насны хүн хүмүүс, нийтдээ 53-54 хөдөлмөрийн бус насны хүмүүсийг тэжээж байгаа ерөнхий дүр зураг харагдаж байна. Статистик тоон мэдээллээ ашиглаж судалгаагаа хийж байх явцад цаашид анхаармаар ажиглагдаж байгаа асуудлууд нь аймгийн ерөнхий боловсролын сургуульд нийт 1502 өнчин хүүхэд сурч байгаагаас 101 бүтэн өнчин хүүхэд, 1401 хагас өнчин хүүхэд байна. Энэ нь гэр бүлийн 52 цуцлалт бүртгэгдсэн ба түүнээс гадна бүртгэлгүй цуцлалт зэргээс шалтгаалж байгаа харгадаж байна. Цаашид гэр бүл салалт болон үр хөндөлтийн шалтгаануудад анхаарал хандуулж урьчилан сэргийлэх арга хэмжээ авах нь зохистой санагдлаа. Мөн аймгийн хэмжээнд 35 цэцэрлэгт 4070 хүүхэд хамрагдах хүчин чадалтай байхад 7368 хүүхэд хамрагдаж байгаа нь цэцэрлэгийн хүртээмж бага байгаа буюу цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хүн амын хөгжилд:

1. Хүн амыг ажлын байраар хангах буюу ямар нэгэн орлогын эх үүсвэртэй болгох
2. Хүн бүр өөрийгөө хөгжүүлэх болон мэргэжил боловсрол эзэмших нөхцөл бололцоог бүрэн хангах
3. Бизнес явуулах таатай орчныг бүрдүүлэх (татвар болон, түрээсийг бууруулах)
4. Ядуу болон нэн ядуу өрхөд амжиргааны эх үүсвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх мөн мэргэжилтэй болоход нь дэмжлэг үзүүлж ажлын байр, орлогын эх үүсвэртэй болох нөхцлийг бүрдүүлэх
5. Эрүүл амьдрах орчин нөхцөлийг нь бүрдүүлж хүн амд эмнэлгийн үйлчилгээг ойртуулах. Хүн амд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлж эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлж амьдарч сурч буй орчиндоо эрүүл мэндэд эергээр нөлөөлөх нөхцлийг бүрдүүлэхэд нь туслах
6. Хүн амыг эрүүл, чанартай, баталгаатай хоол хүнсээр хангах

7. Зээлийн хүүг бууруулж, хөнгөлөлттэй олгогдож байгаа зээлийг шаардлагатай эздэд нь хүргэх мөн хөдөлмөр эрхлэх сонирхолтой, чадвартай зээл хүссэн хүн бүрт зээл олгодог боломжийг бүрдүүлэх

8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд буцалтгүй болон хөнгөлөлттэй зээл тусламж олгож ажлын байраар хангах, тэдний эрүүл мэндийг сайжруулах

Хөдөөд ажлын байр хомс, эрүүл мэнд, боловсрол, соёлын үйлчилгээ тааруу байгаатай холбоотойгоор нийслэл, хотуудыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг буцааж татах хүч сул байна. Төвлөрлийг сааруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөр хэрэгжиж, тодорхой үр дүнд хүрч байгаа хэдий ч бүс нутгуудад хүн амын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах шат дараалсан арга хэмжээ авч, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Нийгэм эдийн засгийн өөрчлөлтийн энэ үед хүн ам зүйн бүтцэд өөрчлөлт нилээд их орж байгаа ба сүүлийн хоёр жилийн хэмжээнд хүн амын дундах төрөлтийн тоо өсөх хандлагатай байна.

Нийгэм эдийн засгийн таатай нөхцөл боломж хот суурин газарт ялангуяа нийслэл Улаанбаатар хотод давамгайлж байгаа мөн хөдөөд дэд бүтэц муу байгаас шилжилт хөдөлгөөнд ихээхэн нөлөөлж байна.

## **Судалгааны хамрах хугацаа**

2012 оныг суурь он болгон авч үзэж 2016 оны жилийн эцсийн байдлаар судалгааг хийсэн

Зарим график, динамикийг сүүлийн 5-7 жилийн үе хугацаагаар харуулав.

## **Мэдээллийн эх үүсвэр**

- Аймгийн судалгааны арга зүйн гарын авлага
- Улсын эмхтгэл
- ҮСХорооноос гаргасан Судалгаа шинжилгээ хийх гарын авлага
- Статистикийн гарын авлага
- [www.NSO.mn](http://www.NSO.mn) сайт
- [www.1212.mn](http://www.1212.mn) сайт
- 2012-2016 оны жилийн эцсийн хүн амын мэдээ



# Хавсралт



## Хүн амын тоо сумаар

Сумдын нэр	2014	2015	2016	2017	2018
Ихтамир	5535	5299	5459	5626	5631
Чулуут	4001	4029	4051	4113	4167
Хангай	3140	3124	3126	3180	3206
Тариат	4755	4702	4761	4839	4981
Өндөр-Улаан	5839	5677	5723	5788	5811
Эрдэнэмандал	5533	5565	5545	5677	5705
Жаргалант	4447	4343	4413	4454	4465
Цэцэрлэг	3856	3718	3758	3801	3821
Хайрхан	3772	3721	3755	3778	3829
Батцэнгэл	3687	3631	3696	3784	3803
Өлзийт	3333	3331	3347	3383	3454
Өгийнуур	3073	3086	3131	3185	3213
Хашаат	3263	3191	3213	3232	3261
Хотонт	4284	4220	4284	4365	4380
Цэнхэр	5592	5685	5743	5892	5917
Төвшрүүлэх	3037	3007	3007	3090	3042
Булган	2508	2521	2622	2713	2757
Эрдэнэбулган	20889	21097	21499	21620	22138
Цахир	2352	2319	2376	2403	2413
Аймгийн дүн	92896	92266	93509	94923	95994

## Хүн амын тоо насны бүлгээр

Насны бүлэг	2014		2015		2016		2017		2018	
	эмэгтэй	бүгд	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй
<b>бүгд</b>	<b>46476</b>	<b>92451</b>	<b>91894</b>	<b>46476</b>	<b>93509</b>	<b>46682</b>	<b>94923</b>	<b>47360</b>	<b>95994</b>	<b>47897</b>
<b>0-4</b>	4851	9745	9608	4851	10950	5402	11132	5430	11232	5494
<b>5-9</b>	3770	7788	7487	3770	9533	4774	9909	4963	10252	5094
<b>10-14</b>	4610	8447	8921	4610	7328	3617	7379	3645	7783	3844
<b>15-19</b>	4856	9560	9482	4856	8874	4330	8669	4265	8184	4043
<b>20-24</b>	4972	10024	10347	4972	8372	3990	8311	3984	8578	4149
<b>25-29</b>	3836	8009	7893	3836	8212	3864	8362	3907	8157	3815
<b>30-34</b>	3553	6977	7032	3553	6980	3382	6996	3421	7078	3391
<b>35-39</b>	3503	6876	6831	3503	6651	3305	6688	3262	6522	3222
<b>40-44</b>	3162	6201	6145	3162	6428	3221	6520	3278	6566	3305
<b>45-49</b>	2672	5483	5330	2672	5653	2919	5765	2939	5836	2914
<b>50-54</b>	2122	4491	4288	2122	4806	2404	4903	2499	5071	2598
<b>55-59</b>	1563	3097	2968	1563	3492	1874	3803	2033	3994	2116
<b>60-64</b>	968	1974	1876	968	2417	1350	2512	1393	2649	1483
<b>65-69</b>	692	1311	1288	692	1387	808	1509	872	1591	915
<b>70+</b>	1346	2468	2398	1346	2426	1442	2465	1469	2501	1514

## Хүн амын өсөлт

он	хүн амын тоо	абсолют цэвэр өсөлт	өсөлтийн хурд	цэвэр өсөлтийн хурд	цэвэр өсөлтийн 1%-д ноогдох утга
2012	91894				
2013	92451	557	100.6061	0.60613	918.94
2014	92896	445	100.4813	0.48134	924.51
2015	92266	-630	99.3218	-0.67818	928.96
2016	93509	1243	101.3472	1.34719	922.66
2017	94923	1414	101.5122	1.51215	935.09
2018	95994	1071	101.1283	1.12828	949.23

### Хүн ам зүй ачаалал

	2013	2014	2015	2016	2017	2018
Ихтамир	49.3	47.8	48.1	50.3	50.8	52.3
Чулуут	57.8	54	55.9	55	54.7	54.8
Хангай	47.7	47.8	47.2	48.4	48.7	50.0
Тариат	44.9	44.7	44.9	45.7	46.1	48.9
Өндөр-Улаан	49.3	48.7	49.6	50.6	51.3	51.7
Эрдэнэмандал	43.3	45.1	47.4	47.1	47.3	49.7
Жаргалант	57.9	55.8	56.4	55.4	54.4	54.7
Цэцэрлэг	53.3	51.9	52.1	52.6	52.7	52.8
Хайрхан	47.5	48.1	48.5	50	51.2	52.7
Батцэнгэл	49	49.2	49.8	50.7	52.9	55.0
Өлзийт	49.2	50.4	51.8	51.1	52.9	54.0
Өгийнуур	50	50.3	50.2	49.7	49.7	49.7
Хашаат	51.1	50.9	50.2	53.1	53.9	56.0
Хотонт	50.8	51	53.1	52.8	53.6	53.6
Цэнхэр	52.9	54.6	54.4	53.1	54.4	56.2
Төвшрүүлэх	45.3	46.8	49.1	49.9	51.0	52.3
Булган	48.3	46.9	47.7	48.1	49.6	51.0
Эрдэнэбулган	39.3	44.3	48.7	51.5	52.3	54.7
Цахир	55.7	59.7	56.3	58.1	59.0	59.0

## Хүн амын төрөлт /1000 хүн амд ногдох/

Сумдын нэр	2014	2015	2016	2017	2018
Ихтамир	27.46	28.12	22.90	27.02	21.49
Чулуут	25.49	22.83	20.24	25.53	19.44
Хангай	24.52	22.09	28.47	23.90	22.46
Тариат	25.87	24.67	23.73	20.87	24.69
Өндөр-Улаан	31.34	21.49	24.64	22.81	25.81
Эрдэнэмандал	27.65	17.79	19.12	19.20	24.36
Жаргалант	29.46	20.26	21.53	22.23	21.95
Цэцэрлэг	23.60	19.37	18.63	18.94	20.94
Хайрхан	24.13	23.38	22.37	20.12	20.11
Батцэнгэл	29.02	20.38	23.00	25.11	24.72
Өлзийт	34.80	23.12	26.59	21.28	24.90
Өгийнуур	26.03	18.47	26.83	22.61	20.23
Хашаат	35.24	26.01	27.70	29.39	23.61
Хотонт	21.71	19.67	19.14	19.93	25.34
ХүЦэнхэр	36.30	25.86	22.46	27.49	25.86
Төвшрүүлэх	34.24	25.27	23.28	22.65	20.05
Булган	24.72	22.21	23.65	22.48	19.22
Эрдэнэбулган	25.95	21.61	26.19	24.56	25.97
Цахир	29.76	22.85	28.20	24.55	24.45
<b>Дүн</b>	<b>27.91</b>	<b>22.28</b>	<b>23.79</b>	<b>23.45</b>	<b>23.19</b>

## Хүүхэд төрүүлсэн эх, насны бүлгээр

Насны бүлэг	2013	2014	2015	2016	2017	2018
15-19	68	174	57	140	132	137
20-24	729	812	616	734	693	743
25-29	661	810	601	671	700	663
30-34	406	472	463	404	420	433
35-39	204	263	237	236	232	238
40-44	44	57	70	37	48	57
45-49	3	5	12	3	1	4
<b>Дүн</b>	<b>2115</b>	<b>2593</b>	<b>2056</b>	<b>2225</b>	<b>2226</b>	<b>2275</b>

### Нас баралт сумаар

Сумдын нэр	2014	2015	2016	2017	2018
Ихтамир	34	38	44	32	37.
Чулуут	20	24	18	12	17.
Хангай	15	31	28	23	25.
Тариат	31	26	39	36	34.
Өндөр-Улаан	22	38	37	32	40.
Эрдэнэмандал	27	40	123	36	27.
Жаргалант	24	31	33	24	27.
Цэцэрлэг	16	20	15	13	36.
Хайрхан	12	22	23	19	27.
Батцэнгэл	19	31	19	25	30.
Өлзийт	10	19	26	19	26.
Өгийнуур	10	21	13	20	22.
Хашаат	15	20	21	18	10.
Хогонт	27	19	27	14	26.
Цэнхэр	29	38	36	34	29.
Төвшрүүлэх	13	20	29	14	21.
Булган	11	24	16	12	15.
Эрдэнэбулган	101	189	123	133	147.
Цахир	14	7	9	17	13.
<b>Аймгийн дүн</b>	<b>450</b>	<b>658</b>	<b>679</b>	<b>533</b>	<b>609.</b>

## Өрхийн тоо сумдаар 2014-2018 он

Сумдын нэр	2014	2015	2016	2017	2018
Ихтамир	1531	1497	1528	1563	1563
Чулуут	1142	1146	1166	1198	1206
Хангай	946	944	950	963	976
Тариат	1442	1423	1449	1480	1524
Өндөр-Улаан	1637	1611	1598	1644	1650
Эрдэнэмандал	1600	1613	1652	1683	1690
Жаргалант	1220	1208	1207	1221	1217
Цэцэрлэг	1057	1054	1059	1107	1109
Хайрхан	1140	1136	1123	1134	1146
Батцэнгэл	1142	1141	1173	1164	1164
Өлзийт	1088	1079	1071	1087	1103
Өгийнуур	926	923	947	953	969
Хашаат	964	949	951	957	962
Хогонт	1329	1314	1307	1335	1322
Цэнхэр	1613	1641	1666	1685	1682
Төвшрүүлэх	900	881	888	894	893
Булган	813	820	865	897	928
Эрдэнэбулган	5620	5707	5812	5872	6087
Цахир	699	695	713	713	721
Аймгийн дүн	26809	26782	27125	27550	27912

## Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2014-2018 он

Сумдын нэр	2014	2015	2016	2017	2018
Ихтамир	128	133	140	145	203
Чулуут	52	184	193	193	175
Хангай	198	149	151	156	142
Тариат	139	263	276	267	276
Өндөрүлаан	133	265	281	270	240
Эрдэнэмандал	154	265	252	252	169
Жаргалант	272	198	207	204	203
Цэцэрлэг	254	126	133	108	159
Хайрхан	122	161	155	155	196
Батцэнгэл	170	129	129	131	123
Өлзийт	154	170	179	194	116
Өгийнуур	110	135	129	118	153
Хашаат	174	118	138	130	112
Хотонт	75	172	159	163	88
Цэнхэр	255	253	258	259	226
Төвшрүүлэх	124	112	109	103	139
Булган	190	55	63	73	88
Эрдэнэбулган	461	465	479	520	648
Цахир	289	80	82	82	67
Аймгийн дүн	3454	3433	3513	3523	3523

## Хагас өнчин хүүхэд 2014-2018 он

Сумдын нэр	2014	2015	2016	2017	2018
Ихтамир	91	76	78	80	62
Чулуут	70	72	63	60	78
Хангай	66	63	66	56	45
Тариат	117	89	74	83	74
Өндөрүлаан	51	39	47	48	67
Эрдэнэмандал	118	99	89	93	78
Жаргалант	82	83	80	86	64
Цэцэрлэг	65	84	80	67	47
Хайрхан	121	125	131	125	73
Батцэнгэл	65	66	62	59	82
Өлзийт	54	60	64	68	50
Өгийнуур	70	70	70	80	43
Хашаат	50	44	41	41	47
Хогонт	102	98	100	102	65
Цэнхэр	113	108	104	127	114
Төвшрүүлэх	58	51	52	71	30
Булган	52	58	55	60	25
Эрдэнэбулган	450	432	435	410	300
Цахир	45	39	39	40	57
Аймгийн дүн	1840	1756	1730	1756	1401

## Бүтэн өнчин хүүхэд 2012-2016 он

Сумдын нэр	2014	2015	2016	2017	2018
Ихтамир	17	4	4	5	7
Чулуут	5	6	5	2	2
Хангай	6	6	5	5	4
Тариат	10	7	8	7	5
Өндөрүлаан	7	5	5	6	2
Эрдэнэмандал	13	9	8	10	5
Жаргалант	0	0	0		13
Цэцэрлэг	5	6	5	1	2
Хайрхан	5	6	6	5	3
Батцэнгэл	3	1	1	2	2
Өлзийт	3	4	4	5	2
Өгийнуур	6	6	6	6	5
Хашаат	2	2	1	1	1
Хотонт	4	4	4	5	2
Цэнхэр	11	9	12	8	10
Төвшрүүлэх	6	6	5	4	8
Булган	0	2	1	1	0
Эрдэнэбулган	42	36	33	35	22
Цахир	10	8	8	8	6
Аймгийн дүн	155	127	121	116	101